ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.15 № 612

танай _____-ны №_____-т

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ц.ТӨРХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2021/46/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он	Аудитын 2 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Долгорсүрэн Утас: 325093 Цахим хаяг: dolgorsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан 6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 9
3.Аудитын тайлан 10
3.1. Ерөнхий зүйл 10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт 10
3.4. Материаллаг байдал 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд 11
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 12
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа 13
3.8. Шилэн дансны мэдээлэл 14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 14
3.10. Аудитын илрүүлэлт 14
Залруулсан алдаа 14
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд 15
4. Менежментийн захидал 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт 18

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.15 № 612

танай _____-ны №_____-т

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ц.ТӨРХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, эорилтот түвшний хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

00202054.0

Санхүүгийн тайланг залилан эсвэл алданы улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	27,319,156,558.74	22,896,346,967.00
1.1.2	Дансны авлага	6,583,571,873.71	9,094,177,857.20
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	129,782,554.26	476,249,221.60
1.1.4	Бусад авлага	1,094,363.01	1,293,370.31
1.1.6	Бараа материал	6,593,216,759.34	10,200,734,723.14
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	429,462,514.30	458,861,040.90
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	41,056,284,623	43,127,663,180.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	256,066,514,995.9	251,830,503,521.9
1.2.2	Биет бус хөрөнгө	111,565,245,523.0	111,778,679,536.2
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	415,800,895.27	1,591,609,986.18
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	368,047,561,414	365,200,793,044.22
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	409,103,846,038	408,328,456,224.37
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,404,613,385.55	1,506,977,929.53
2.1.1.3	Татварын өр	126,494,097.84	66,125,082.55
2.1.1.6	Хүүгийн өглөг	4,719,186,487.10	4,916,023,906.62
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	599,327,054.12	768,695,435.59
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	47,117,345.28	42,319,257.42
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,896,738,370	7,300,141,611.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	133,690,187,252.97	139,641,243,314.77
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	57,789,004,098.29	64,770,230,248.28
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	191,479,191,351.26	204,411,473,563.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	198,375,929,721.15	211,711,615,174.76
	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	874,877,566.30	874,877,566.30
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,945,038,866.86	111,938,139,567.97
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	275,922,698,596.99	289,418,158,653.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(178,014,698,713.71)	(205,614,334,737.66)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(178,014,698,713.71)	(27,189,373,028.94)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг		(178,424,961,708.72)
2.3.11	Эздийн өмчийн дүн	210,727,916,316.44	196,616,841,049.61
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	409,103,846,037.59	408,328,456,224.37

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	62,456,738,518.14	63,223,129,596.39
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	67,686,062,078.06	74,534,210,520.72
3	**Нийт ашиг (алдагдал)**	**(5,229,323,560)**	**(11,311,080,924.33)**
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	1,949,387,457.78	1,843,228,935.10
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,643,801,663.34	2,033,947,190.58
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,607,066,868.17	2,914,965,487.30
11	Санхүүгийн зардал	4,564,485,077.78	4,709,588,384.90
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,818,680,371.22)	(8,418,074,861.23)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	315,445.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	427,048,444.23	539,062,332.81
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**(16,486,921,638)**	**(27,005,050,135.43)**
19	Орлогын татварын зардал	376,940,886.00	184,322,893.51
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	**(16,863,862,524)**	**(27,189,373,028.94)**
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**(16,863,862,524)**	**(27,189,373,028.94)**
23	**Бусад дэлгэрэнгүй орлого**	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	**Нийт дэлгэрэнгүй орлогын дүн**	**(16,863,862,524)**	**(27,189,373,028.94)**
25	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**874,877,566.30**	**111,948,871,738.84**	**274,152,531,183.55**	**(160,671,675,291.49)**	**226,304,605,197.20**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(479,160,897.80)	(479,160,897.80)
Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,948,871,738.84	274,152,531,183.55	(161,150,836,189.29)	225,825,444,299.40
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(16,863,862,524.42)	(16,863,862,524.42)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			1,770,167,413.44		1,770,167,413.44
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(3,832,871.98)			(3,832,871.98)
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**874,877,566.30**	**111,945,038,866.86**	**275,922,698,596.99**	**(178,014,698,713.71)**	**210,727,916,316.44**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				8,551,083.46	8,551,083.46
Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,945,038,866.86	275,922,698,596.99	(178,006,147,630.25)	210,736,467,399.90
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(27,189,373,028.94)	(27,189,373,028.94)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			13,495,460,056.01	(418,814,078.47)	13,076,645,977.54
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(6,899,298.89)			(6,899,298.89)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**874,877,566.30**	**111,938,139,567.97**	**289,418,158,653.00**	**(205,614,334,737.66)**	**196,616,841,049.61**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**73,798,255,679.14**	**71,175,747,125.84**
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	69,090,839,690.38	68,226,239,162.36
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,199,500.00	1,407,240.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	1,370,366,395.90	135,965,755.54
	Бусад мөнгөн орлого	3,335,850,092.86	2,812,134,967.94
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**61,222,329,221.97**	**66,703,275,767.19**
	Ажиллагчдад төлсөн	21,848,001,912.21	25,634,425,482.41
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,348,299,783.00	7,556,047,015.79
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,637,010,913.29	6,687,930,532.40
	Ашиглалтын зардалд төлсөн	13,153,765,476.81	13,849,355,099.98
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,576,547,642.79	2,936,253,636.16
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	7,681,192,658.21	7,269,995,940.22
	Даатгалын төлбөрт төлсөн	119,292,359.30	109,840,050.39
	Бусад мөнгөн зарлага	2,858,218,476.36	2,659,428,009.84
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**12,575,926,457.17**	**4,472,471,358.65**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**9,015,633,726.87**	**8,896,737,335.57**
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,898,388,797.36	8,754,013,405.57
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	117,244,929.51	142,723,930.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(9,015,633,726.87)**	**(8,896,737,335.57)**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**244,198.85**	**1,513,655.40**
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад	244,198.85	1,513,655.40
3.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**364,994.79**	**57,270.22**
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Бусад	364,994.79	57,270.22
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(120,795.94)**	**1,456,385.18**
4	**Валютын ханшийн зөрүү**		
5	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**3,560,171,934.36**	**(4,422,809,591.74)**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**23,758,984,624.38**	**27,319,156,558.74**
7	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**27,319,156,558.74**	**22,896,346,967.00**

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	**Нийт орлогын дүн**	**65,375,470.0**	**63,223,129.5**	**(2,152,340.5)**	96.7
1.1	Цэвэр усны орлого	35,109,800.0	34,069,900.8	(1,039,899.2)	97.0
1.2	Бохир ус татан зайлуулсан орлого	27,868,070.0	26,805,575.9	(1,062,494.1)	96.2
1.3	Бусад орлого	2,397,600.0	2,347,652.7	(49,947.3)	97.9
2	**Нийт зардал**	**95,995,407.4**	**84,192,711.6**	**(11,802,695.8)**	87.7
2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	30,435,636.1	29,319,426.7	(1,116,209.4)	96.3
2..2	Ажил олгогчоос эмнэлгийн хуудсаар олгосон	34,880.0	69,474.5	34,594.5	199.2
2.3	НДШ, ЭМД	4,156,077.5	4,010,191.8	(145,885.7)	96.5
2.4	Хоол, унаа	1,699,853.0	1,611,978.8	(87,874.2)	94.8
2.5	Сургалт	156,580.0	28,175.9	(128,404.1)	18.0
2.6	Тэтгэмж болон нийгмийн арга хэмжээ	334,537.5	316,912.6	(17,624.9)	94.7
2.7	Шагнал	37,600.0	26,579.9	(11,020.1)	70.7
2.8	Хлор, манганы сульфат, бодис, давс	2,551,960.6	1,373,447.9	(1,178,512.7)	53.8
2.90	Сэлбэг, багаж хэрэгсэл	1,608,932.5	1,241,608.1	(367,324.4)	77.2
2.10	Хангамжийн зардал	143,375.4	151,611.7	8,236.3	105.7
2.11	Түлээ, нүүрс	61,692.2	45,001.0	(16,691.2)	72.9
2.12	Шатахуун, тосолгоо	2,628,284.0	2,070,038.2	(558,245.8)	78.8
2.13	Цахилгаан	13,379,093.6	11,935,425.1	(1,443,668.5)	89.2
2.14	Дулаан, СӨХ	411,703.9	263,507.4	(148,196.5)	64.0
2.15	Ус	39,724.0	46,039.4	6,315.4	115.9
2.16	Харуул, хамгаалалт	248,181.8	231,860.0	(16,321.8)	93.4
2.17	Урсгал засвар, аваар,аваарын нөөц сан, тохижилт	2,026,290.9	1,228,125.8	(798,165.1)	60.6
2.18	Лагийн зардал	37,767.6	33,925.1	(3,842.5)	89.8
2.19	Бичиг хэрэг	83,642.4	66,839.3	(16,803.1)	79.9
2.20	Холбоо шуудан холбоо, хэвлэл захиалга	189,454.5	160,736.4	(28,718.1)	84.8
2.21	Томилолт	97,141.0	192.0	(96,949.0)	0.2
2.22	Зар сурталчилгаа, олон нийтийн зардал	147,240.0	140,124.7	(7,115.3)	95.2
2.23	Гаднын үйлчилгээ	59,908.5	26,784.9	(33,123.6)	44.7
2.24	Банкны үйлчилгээ	3,856.6	1,254.9	(2,601.7)	32.5
2.25	Хөдөлмөр хамгаалал	928,940.9	915,892.8	(13,048.1)	98.6
2.26	Лабораторийн зардал	227,457.4	179,874.2	(47,583.2)	79.1
2.27	Төслийн зардал	290,615.6	228,391.8	(62,223.8)	78.6
2.28	УЗ-ын зардал	42,397.6	25,568.4	(16,829.2)	60.3
2.29	Найдваргүй авлагын зардал	57,390.0	99,926.1	42,536.1	174.1
2.30	Татвар, хураамжийн зардал	903,876.1	896,801.8	(7,074.3)	99.2
2.31	Даатгал	122,592.1	81,245.0	(41,347.1)	66.3
2.32	Зээлийн хүүгийн зардал	4,707,048.2	4,709,588.4	2,540.2	100.1
2.33	Элэгдлийн зардал	**28,141,675.9**	22,656,161.0	**(5,485,514.9)**	80.5
3	**Үйл ажиллагааны алдагдал**	**(30,619,937.4)**	**(20,969,582.1)**	**9,650,355.3**	68.5
4	**Үйл ажиллагааны орлогын 1 төгрөгт ногдох зардал**	**1.47**	**1.33**	**(0.14)**	90.7
5	Үйл ажиллагааны бус орлого	2,784,176.5	2,889,639.1	105,462.6	103.8
6	Үйл ажиллагааны бус зардал	373,836.9	8,925,107.2	8,551,270.3	2,387.4
7	**Нийт орлого**	**68,159,646.5**	**66,112,768.6**	**(2,046,877.9)**	97.0
8	**Нийт зардал**	**96,369,244.3**	**93,117,818.7**	**(3,251,425.6)**	96.6
9	**ОНТНЗ**	**1.41**	**1.41**	**(0.01)**	99.6
10	**Татвар төлөхийн өмнөх алдагдал**	**(28,209,597.8)**	**(27,005,050.1)**	**1,204,547.7**	95.7
11	**Орлогын татварын зардал**	**376,940.9**	**184,322.9**	**(192,618.0)**	48.9
12	**Тайлант үеийн цэвэр алдагдал**	**(28,586,538.70)**	**(27,189,373.0)**	**1,397,165.7**	95.1
13	Авлага	658,3571.9	9,094,177.9	2,510,606.0	138.1
14	Нийт өр төлбөр	198,375,929.7	211,711,615.2	13,335,685.5	106.7
15	Хөрөнгө оруулалт	11,827,800.0	8,896,737.0	(2,931,063.0)	75.2
16	Орон тоо	1892	1803	(89)	95.3

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Ц.Төрхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал зөв бүртгэх болон цалинтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15–ны хооронд НТАГ-ын Аудитын 2 дугаар хэлтсийн ахлах аудитор Г.Долгорсүрэн, аудитор Х.Оюунчимэг, Н.Бадамхатан, М.Нарангэрэл, Н.Энхмэнд, Ш.Мөнхжаргал, Э.Ундармаа, гэрээт аудитор Р.Түмэн-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланг НТАГ-т 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/144 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийг 100.0 хувь төр эзэмшиж байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Нийслэлийн хүн ам, албан байгууллагуудад стандартын шаардлага хангасан цэвэр усаар тасралтгүй хангах, бохирдсон усыг зохих стандартын дагуу цэвэрлэж зайлуулах, хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийж хяналт тавих, эзэмшлийн инженерийн шугам, сүлжээ, тоноглолд технологийн шинэчлэлт хийх” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Үйл ажиллагааны хяналтын хэлтэс нь зохион байгуулалтын хяналтын нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд 13 удаагийн хяналт шалгалт хийж 21.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж холбогдох зөвлөмжийг өгсөн байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 66,138,422.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 661,384.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзээд материаллаг байдлын түвшнийг тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 66,112,768.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 661,127.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 775,390.0 мянган төгрөгөөр буюу 16.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,319,156.6	22,896,347.0	(4,422,809.6)
Авлага	6,714,448.8	9,571,720.4	2,857,271.6
Урьдчилгаа	429,462.5	458,861.0	29,398.5
Бараа материал	6,593,216.8	10,200,734.7	3,607,517.9
Үндсэн хөрөнгө	368,047,561.4	365,200,793.0	(2,846,768.4)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**409,103,846.1**	**408,328,456.1**	**(775,390.0)**
Богино хугацаат өр төлбөр	6,896,738.4	7,300,141.6	403,403.2
Урт хугацаат өр төлбөр	191,479,191.3	204,411,473.5	12,932,282.2
Өмч:	874,877.6	874,877.6	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,945,038.9	111,938,139.5	(6,899.4)
Эздийн өмчийн бусад хэсэг	275,922,698.6	289,418,158.6	13,495,460.0
Хуримтлагдсан ашиг	(178,014,698.7)	(205,614,334.7)	(27,599,636.0)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**409,103,846.1**	**408,328,456.1**	**(775,390.0)**

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн бусад хэсэг дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 22,896,347.0 мянган төгрөг болж 4,422,809.6 мянган төгрөгөөр буурахад Ковид-19 цар тахлын улмаас борлуулалтын орлого буурсан нь шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 9,571,720.4 мянган төгрөг болж 2,857,271.6 мянган төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон

зарим аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх болсонтой холбоотой.

Авлага дансны үлдэгдэлд 4-өөс дээш жилийн насжилттай 775,223.5 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй нь нийт авлагын 8.1 хувийг эзэлж байна. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 2009 оны тогтоолоор найдваргүй авлагын нөөцийг авлагын эцсийн үлдэгдлийн 3-5 хувиар байгуулахаар тогтсон бөгөөд тайлант онд 373,801.6 мянган төгрөгийн авлагыг найдваргүй авлагаар бүртгэсэн.

Бараа материал тайлант онд худалдан авсан 21,146,336.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 17,538,818.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 10,769,234.0 мянга, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 7,332,575.4 мянга, нийт 18,101,809.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, холбогдох байгууллагын шийдвэрээр акталсан 9,019,808.2 мянга, биет бус хөрөнгөд шилжүүлсэн 162,949.6 мянга, балансаас баланст шилжүүлсэн 99,828.2 мянга, нийт 9,282,586.0 мянган төгрөгөөр буурсан.

Биет бус хөрөнгө тайлант онд бүртгэсэн газрын үнэлгээ 399,460.1 мянга, биет хөрөнгөөс шилжиж ирсэн 162,949.6 мянга, өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 140,302.7 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 34,260.9 мянга, нийт 736,973.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 7,184.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 7,300,141.6 мянган төгрөг нь зээлийн хүүгийн өр төлбөр 4,916,023.9 мянга, хөрөнгө оруулалтын барьцаа 1,263,882.4 мянга, урьдчилж орсон орлого 768,695.4 мянга, бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх 227,371.1 мянга, татварын өр төлбөр 66,125.1 мянга, ажиллагсдын барьцаа 42,128.2 мянга, хэмжүүр баталгааны 15,915.5 мянган төгрөгөөс бүрдсэн.

Урт хугацаат өр төлбөр 12,932,282.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ам.доллар 115.56 төгрөгөөр, евро 440.97 төгрөгөөр нэмэгдсэн мөн богино хугацаат өр төлбөр данснаас шилжиж ирсэн зээлийн хүүгийн зардал бүртгэсэнтэй холбоотой.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 111,938,139.5 мянган төгрөг болж 6,899.4 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгө бүртгэлээс хасагдсантай холбоотой.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 289,418,158.6 мянган төгрөг болж 13,495,460.1 мянган төгрөгөөр өсөхөд шугам доторлогооны төслөөр 8,928,329.0 мянга, улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар 4,166,041.8 мянга, газрын өртөг 399,480.1 мянга, хандив тусламжийн 1,609.2 мянга төгрөгийн хөрөнгө бүртгэсэн нь шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргатай 2020 оны 6 дугаар зүйлийн 26-ны өдөр гэрээ байгуулж 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 68,159,646.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 96,746,185.2 мянган төгрөгөөр, алдагдлыг 28,586,538.7 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 11,827,800.0 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан нь урт хугацаат зээлийн дансанд гадаад валютыг зээлийн үлдэгдэл, хүүгийн өглөгт ханшийн тэгшитгэл бүртгэдэгтэй холбоотой.

Гүйцэтгэлээр 66,112,768.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 93,302,141.6 мянган төгрөгийн зардал гарган, 27,189,373.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

Хүснэгт 2. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	**Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт**						
	Борлуулах ус	M^3	46,148.1	46,381.5	44,322.0	2,059.5	95.6
	Татан зайлуулах ус	M^3	46,670.2	46,837.5	44,631.5	2,206.0	95.3
2	**Нийт орлого**		**66,138,422.5**	**68,159,646.5**	**66,112,768.6**	**2,046,877.9**	**97.0**
	Үүнээс: Цэвэр борлуулалт		62,456,738.5	65,375,470.0	63,223,129.5	2,152,340.5	96.7
3	**Нийт зардал**		**82,625,344.1**	**96,369,244.3**	**93,117,818.7**	**3,251,425.6**	**96.6**
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		67,686,062.1	85,935,557.5	74,534,210.5	11,401,347.0	86.7
	б) Ерөнхий ба удирдлагын зардал		8,815,353.6	10,060,850.1	9,658,501.1	402,349.0	96.0
	в) Хөрөнгө оруулалт их засвар		15,806,800.0	11,827,800.0	8,896,737.0	2,931,063.0	75.2
4	**Цэвэр ашиг, алдагдал**		**(16,486,921.6)**	**(28,209,597.8)**	**(27,005,050.1)**	**(1,204,547.7)**	**95.7**

Нийт орлогын гүйцэтгэл 66,112,768.6 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,046,877.9 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар тасарсан нь Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоож зарим аж ахуйн нэгж, байгууллага ажиллаагүйтэй холбоотой.

Нийт зардлын гүйцэтгэл 93,302,141.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 3,251,425.6 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан нисэхийн цэвэрлэх байгууламж, зарим усан сан, лаг усгүйжүүлэх байгууламж ашиглалтад ороогүйгээс цалингийн зардал, элэгдлийн зардал, ашиглалтын зардал, бодисын зардлыг дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу улс, нийслэлийн төсвөөс 4,166,041.8 мянга, төсөл хөтөлбөрөөс 8,928,329.0 мянга, өөрийн эх үүсвэрээс 8,896,737.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 27,189,373.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,397,165.7 мянган төгрөгөөр дутуу байгаа нь 3.0 хувиар орлого тасарсан нь шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын ТУЗ нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал

хариуцсан нэгдүгээр орлогч, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 3 төлөөлөгч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга, орлогч дарга, нийт 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. ТУЗ-ийн хурлыг 2020 онд 1 удаа зохион байгуулж 1 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 42,397.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр цалин, урамшууллын зардалд 21,700.0 мянга, НДШ-ийн зардалд 2,495.5 мянга, бусад зардалд 1,372.9 мянга, нийт 25,568.4 мянган төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 11 мэдээллийг хугацаа хоцроосон, байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг сар бүр мэдээлээгүй, улиралд нэг удаа мэдээлсэн, 2020 оны жилийн эцэст мэдээлэхдээ гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг бичээгүй.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	107,739.4	1	107,739.4	100.0
Зөвлөмж	1	19,800.0	1	19,800.0	100.0
Нийт дүн	**2**	**127,539.4**	**2**	**127,539.4**	100.0

Өмнөх аудитаар 14,362.8 мянган төгрөгийн авлага, 93,376.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын онцлогтой холбоотой бүртгэлийн тусгай бодлогыг тусгах зөвлөмж өгсөн.

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 277,763.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 38,573.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 147,273.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 91,916.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын алба, нэгжүүдийн санхүүгийн тайлангаар бусад санхүүгийн хөрөнгө данс нь 43,905,688.2 мянган төгрөгийн хасах тэмдэгтэй

үлдэгдэл тайлагнасан. Иймд нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө СТУОС-ыг мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн байгууллагын онцлогтой холбоотой бодлогыг тусгах нь зүйтэй.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. 2015 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан, эзэн холбогдогч тодорхойгүй 37,155.9 мянган төгрөгийн барьцааг орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*үнэн зөв байх*", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "*Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.*" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Үр дүнгийн урамшуулал олгохдоо байгууллагын даргын тушаалыг зөрчиж урамшууллын хувийг өөрчлөн 1,417.3 мянган төгрөг илүү олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "*Төрийн өмчийн төлөөлөгч дараах эрх үүрэгтэй ... 3/ олгогдсон эрх хэмжээнийхээ дотор төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх*" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Нийт 17,784.8 мянган төгрөгийн авлага, 129,488.4 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, бариментжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гүйцэтгэж амжаагүй дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэхээр тогтлоо. Үүнд:

- Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт болон бэлэн мөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад биет тест хэрэгжүүлэх;

- Байгууллагын даргын шийдвэрээр ажиллагсдад үр дүнгийн урамшуулал сар бүр 42 хүртэл хувиар олгож байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 "*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.*" заалтыг зөрчиж байгааг судлах;

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр мэргэшсэн хүний нөөц, мэргэшсэн дотоод аудиторт 10,094.1 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*үнэн зөв байх*" заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:
Төсөв хэтрэх

1.3. Өгсөн зөвлөмж:
Холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн зэргийн нэмэгдэл олгож байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:
Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчдад 16,442.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 12.2.в "*...сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жилийн хугацаанд дахин сахилгын зөрчил гаргаагүй бол уг ажилтныг сахилгын шийтгэлгүйд тооцно*" заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:
Цалингийн зардал хэтрэх

2.3. Өгсөн зөвлөмж:
Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:
Цалин хөлснөөс ХХОАТ, НДШ, цалингийн урьдчилгаанаас бусад 9,320.0 мянган төгрөгийн суутгал хийсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:
Цалингийн зардлын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:
Цалингаас Хөдөлмөрийн тухай хуульд заагдаагүй суутгал хийхгүй байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:
Цалингаас тооцсон шийтгэлийн дүнгээр үндсэн цалин болон дагалдах нэмэгдлүүдийг багасгаж тооцон, 4,191.9 мянган төгрөгөөр цалингийн зардлаа бууруулан тайлагнасан НББОУС-25 "Ажилчдын тэтгэвэр,тэтгэмж" стандартын "*Богино хугацааны тэтгэмжийг цэвэр дүнгээр гаргахыг зөвшөөрөхгүй*" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:
Цалингийн зардлын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

4.3. Өгсөн зөвлөмж:
Цалингийн тооцоолол зөв бүртгэх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

5. Балансын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:
Бараа материал дансанд 5,812.8 мянган төгрөгийн хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал"-ын 4.5 "*Бараа материалын орлого зарлагын журналыг бараа, түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн зүйлс гэх мэт үндсэн ангиллаар дэлгэрүүлж хөтөлнө.*" заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:
Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

5.3. Өгсөн зөвлөмж:
Хөрөнгийн ангилал зөв бүртгэх

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

6. Балансын данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:
Үндсэн хөрөнгийн шинжтэй 10,030.6 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн нь НББОУС-ын 16 "*Үндсэн хөрөнгө гэдэг нь нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах хөрөнгө*", 2 "*Бараа материал гэдэг нь үйлдвэрлэлийн дамжлага эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө*" заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

6.2. Эрсдэл:
Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

6.3. Өгсөн зөвлөмж:
Хөрөнгийн ангилал зөв бүртгэх

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

7. Балансын данстай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:
Барилгын их засварын ажлын барьцаа 36 сарын хугацаатай гүйцэтгэлийн баталгааны өглөг 36,024.9 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын Богино хугацаат өр төлбөр бүлэгт "*Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр гэнэ*." заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

7.2. Эрсдэл:
Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

7.3. Өгсөн зөвлөмж:
Өр төлбөрийн ангилал зөв бүртгэх

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Байгууллагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр	Аудитын код
2020.03.15	*Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит*	НТАГ-2021/46/СТА-ОНӨААН

Шалгагдсан байгууллагын нэр	Мөнгөн төгрөгөөр
Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2015 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан, эзэн холбогдогч тодорхойгүй 37,155.9 мянган төгрөгийн барьцааг орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй.	37,155.9	Төлбөрийн акт тогтоов	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн

2	Нийт 17,784.8 мянган төгрөгийн авлага, 129,488.4 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.	147,273.2	Албан шаардлага өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
3	Мэргэшсэн хүний нөөц, мэргэшсэн дотоод аудиторт мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон.	10,094.1	Зөвлөмж өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
4	Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон.	16,442.3	Зөвлөмж өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
5	Цалин хөлснөөс ХХОАТ, НДШ, цалингийн урьдчилгаанаас бусад суутгал хийсэн.	9,320.0	Зөвлөмж өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
6	Үр дүнгийн урамшуулал олгох байгууллагын даргын тушаалыг зөрчиж урамшууллын хувийг өөрчлөн илүү олгосон.	1,417.3	Төлбөрийн акт тогтоов	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
7	Цалингаас тооцсон шийтгэлийн дүнгээр үндсэн цалин болон дагалдах нэмэгдлүүдийг багасгаж тооцон, цалингийн зардлаа бууруулан тайлагнасан.	4,191.9	Зөвлөмж өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
8	Бараа материалын ангилал зөрүүтэй бүртгэсэн.	5,812.8	Зөвлөмж өгөх	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
9	Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалд бүртгэсэн.	10,030.6	Зөвлөмж өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
10	Барилгын их засварын ажлын барьцаа 36 сарын хугацаатай гүйцэтгэлийн баталгааны өглөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн.	36,024.9	Зөвлөмж өгөв	Дарга, Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Төрхүү, Ч.Ариунаа, Т.Даваасүрэн
ДҮН		**277,763.0**			

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Аудитын 2 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер — З.Мөнхбаяр

Аудитын менежер — Д.Отгонбаяр

Бэлтгэсэн:

Ахлах аудитор — Г.Долгорсүрэн